

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД, БОЛОВСРОЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

20 ... оны ... дугаар
сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Автотээврийн салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн яамны Автотээврийн бодлого, зохицуулалтын газар /Э.Мөнхнасан/, Боловсролын яамны /...../-т тус тус даалгасугай.

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД

БОЛОВСРОЛЫН САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Б.НАРАНБАЯР

*Зам, тээврийн сайд,
Боловсролын сайдын
20... оны ... дугаар сарын ... -ны
өдрийн ... / ... дугаар
хамтарсан тушаалын хавсралт*

**АВТОТЭЭВРИЙН САЛБАРЫН МЭРГЭЖИЛТЭЙ АЖИЛТАН
БЭЛТГЭХ, ДАВТАН СУРГАХ, МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ, МЭРГЭЖЛИЙН
ЗЭРЭГ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Монгол Улсын автотээврийн салбарын (цаашид “салбар” гэх) мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх сургалтыг тасралтгүй зохион байгуулах, мэргэжлийн зэрэг олгох, сунгах, цуцлах, хяналт тавих, сургалтын тогтолцоотой холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Автотээврийн салбарын мэргэжилтэн гэдэгт авто инженер, авто хөдөлгүүрт механик инженер, машин механизмын ашиглалтын инженер, мехатроникийн инженер, машин үйлдвэрлэлийн инженер, үйлдвэрийн механикжуулалтын инженер, барилга замын машин механизмын инженер, машин үйлдвэрийн инженер, машины электрон системийн инженер, тээврийн менежмент, нийлүүлэлтийн сүлжээ, логистикийн мэргэжилтнүүд хамаарна.

1.3. Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, даван сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох үйл ажиллагааг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай гэрээ байгуулсан эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ.

1.4. Автотээврийн салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, даван сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох, сургалт зохион байгуулах үйл ажиллагааг Автотээврийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль болон энэхүү журмаар зохицуулна.

1.5. Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох, сунгах, цуцлах, хяналт тавих, сургалтын тогтолцоог боловсронгуй болгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүргийг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Автотээврийн салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох орон тооны бус Зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ хариуцана.

1.6. Инженерчлэлийн чиглэлээр төгссөн мэргэжилтнүүд нь “зөвлөх ба мэргэшсэн инженер”-ийн зэргийг, харин тээврийн менежмент, нийлүүлэлтийн сүлжээ, логистикийн чиглэлээр төгссөн мэргэжилтнүүд нь “зөвлөх ба мэргэшсэн менежер”-ийн зэргийг горилно.

**Хоёр. Автотээврийн салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх,
мэргэжлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл**

2.1. Автотээврийн салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох орон тооны бус Зөвлөлийн

бүрэлдэхүүнийг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга батална.

2.2. Зөвлөл нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх ба зөвлөлийг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Автотээврийн асуудал хариуцсан нэгжийн дарга ахалж ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүний 70-аас доошгүй хувь нь зөвлөх зэрэгтэй инженер байна.

2.3. Зөвлөлийн бүрэлдэхүүнд автотээврийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж буй их, дээд сургууль, коллежийн төлөөлөл, эрдэм, шинжилгээ, судалгааны байгууллага болон автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл байна.

2.4. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдаанаар салбарын мэргэжилтэнд зэрэг олгох мэргэжлийн хүрээ, мэргэжлийн зэрэг горилогчдод зориулан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, мэргэжил дээшлүүлэх шалгалтын журам, зөвлөх зэрэг горилох сэдвийн жагсаалтыг баталгаажуулах, мэргэжлийн зэрэг горилох шалгаруулалтын дүн, мэргэжлийн зэрэг олгох, сунгах, цуцлах асуудлыг тус тус хэлэлцэнэ.

2.5. Зөвлөл нь дор дурдсан эрх, үүрэгтэй.

2.5.1. Зөвлөл нь дарга, нарийн бичиг, гишүүд гэсэн бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөлийн дарга, гишүүд нь салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох үйл ажиллагааг Автотээврийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомж, эрх зүйн актын хүрээнд удирдан зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

2.5.2. Холбогдох дүрэм, журмыг чанд баримтлан ашиг сонирхлын зөрчилгүй, үнэнч шударга ажиллана.

2.5.3. Мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг горилогчдод зориулсан сургалтын багц цагийн үнэлгээг тухай бүрт нь хэлэлцэн шийдвэрлэнэ.

2.5.4. Шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг баталж, шалгалтын комиссыг Зөвлөлийн гишүүн ахална. Комиссоос гаргасан шийдвэр шаардлага хангаагүй тохиолдолд шалгалтын комиссыг дахин томилон ажиллуулна.

2.5.5. Мэргэжлийн зэрэг горилогч нь мэргэжлийн алдаа, дутагдал, гаргасан нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон, мөн ёс зүйн зөрчил гаргасан бол Зөвлөлийн хурлаар мэргэжлийн зэргийг цуцлах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

2.5.6. Зөвлөл нь сургалт, шалгаруулалттай холбогдон гарсан аливаа маргаан, гомдол, санал, хүсэлтийг холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд шийдвэрлэнэ.

2.5.7. Зөвлөлийн хурал нь 75-аас доошгүй хувийн ирцтэй хуралдаж, шийдвэрийг олонхийн саналаар гаргана. Зөвлөлийн хурлын шийдвэрийг Зөвлөлийн дарга баталгаажуулна.

2.5.8. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын энэхүү сургалтыг хариуцсан ажилтан байна.

2.5.9. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хурлын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах, хурлаас гаргасан шийдвэрийг албажуулах, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих, бусад холбогдох мэдээллээр хангах ажлыг хариуцаж, зохион байгуулна. Нарийн бичгийн дарга нь хуралд саналын эрхгүй оролцоно.

Гурав. Мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох сургалтын үйл ажиллагаа

3.1. Салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох сургалтын үйл ажиллагааг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай гэрээ байгуулсан эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ.

3.2. Автотээврийн салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох, сунгах сургалтыг зохион байгуулах, хэрэгжүүлэх байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна.

3.2.1. Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагаас авсан байх;

3.2.2. Сургалтын байгууллага нь анги танхим, сургалтын материал, техник, тоног төхөөрөмжийн хувьд сургалтын байгууллагад тавигдах стандарт шаардлагыг бүрэн хангасан байх;

3.2.3. Сургалтын чиг хандлагад нийцсэн, салбарын мэргэжилтний чадавхийг сайжруулах талаар сургалтын нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөө, аргачлалтай байх;

3.2.4. Сургагч багш нь мэргэжлийн мэргэшсэн болон зөвлөх зэрэгтэй инженер, боловсролын зэрэг нь магистраас доошгүй байх.

3.3. Сургалтын байгууллага нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.3.1. Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөр болон батлагдсан төлөвлөгөөний дагуу сургалтын нэг багц цагийн үнэлгээг тооцож, Зөвлөлөөр батлуулах;

3.3.2. Сургалтын төлөвлөгөөний дагуу мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэжлийн зэрэг олгох сургалтыг зохион байгуулж, хэрэгжүүлэх;

3.3.3. Сургалтыг “Автотээврийн салбарын хүний нөөц, сургалтын мэдээллийн нэгдсэн систем” (цаашид “нэгдсэн систем” гэх)-ээр дамжуулан зохион байгуулах;

3.3.4. Сургалтыг танхим, цахим болон бусад боломжит хэлбэрээр явуулах;

3.3.5. Сургалтыг суурь боловсролд тулгуурлан дөрөвдүгээр хавсралтад заасан мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох хүрээний хязгаарт явуулах;

3.3.6. Сургалтын үйл ажиллагааны талаарх мэдээллийг нэгдсэн санд бүртгэн хөтөлж, мэдээлэл, лавлагаагаар байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд үйлчлэх;

3.3.7. Сургалтын үйл ажиллагааны тайлан, мэдээг хөтлөх, тайлан, мэдээ, дүгнэлтээ хагас жил тутамд Зөвлөлд тайлагнах;

3.3.8. Сургалтын нэгдсэн систем ашиглахтай холбоотой дүрэм, зааврыг боловсруулан, тараах, түгээх;

3.3.9. Сургалттай холбоотой бичиг баримт /хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, суралцагчдын судалгаа, шалгалтын материал, санал хүсэлт г.м/-ыг архивын нэгж болгон 5 жил хүртэл хугацаагаар хадгалах;

3.3.10. Мэргэжил дээшлүүлэх сургалтын чиглэлээр ижил төстэй мэргэжлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах;

3.3.11. Мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх сургалтын талаарх салбарын үйл ажиллагааны хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө боловсруулахад оролцох.

3.4. Сургалтын нийт багц цагийг дараах байдлаар тооцно.

Суралцагчид	Нийт үзэх		Заавал суралцах		Сонгон суралцах		Бие даан суралцах	
	Багцаар	Цагаар	Багцаар	Цагаар	Багцаар	Цагаар	Багцаар	Цагаар
Зөвлөх зэрэг горилогч	20	240	5	40	5	40	10	160
Зөвлөх зэрэгтэй мэргэжилтэн	15	200	3	24	2	16	10	160
Мэргэшсэн зэрэг горилогч	10	136	3	24	-	-	7	112
Мэргэшсэн зэрэгтэй мэргэжилтэн	15	200	2	16	3	24	10	160

3.4.1. Мэргэшсэн зэрэг горилогчийн сургалтын цаг:

Сургалтын төрөл	Багц	Цаг
Заавал суралцах	3	24
Сонгон суралцах		
Бие даан суралцах	7	112
Нийт багц/цаг	10	136

3.4.2. Мэргэшсэн зэрэгтэй мэргэжилтний сургалтын цаг:

Сургалтын төрөл	Багц	Цаг
Заавал суралцах	2	16
Сонгон суралцах	3	24
Бие даан суралцах	10	160
Нийт багц/цаг	15	200

3.4.3. Зөвлөх зэрэг горилогчийн сургалтын цаг:

Сургалтын төрөл	Багц	Цаг
Заавал суралцах	5	40
Сонгон суралцах	5	40
Бие даан суралцах	10	160
Нийт багц/цаг	20	240

3.4.4. Зөвлөх зэрэгтэй мэргэжилтний сургалтын цаг:

Сургалтын төрөл	Багц	Цаг
Заавал суралцах	3	24
Сонгон суралцах	2	16
Бие даан суралцах	10	160
Нийт багц/цаг	15	200

3.4.5. Сургалтын хэлбэрээр багц цагийг тооцохдоо танхимын 8 цагийг 1 багц цаг, дадлага сургалтын 16 цагийг сургалтын 1 багц цаг гэж тус тус тооцно. Нэг цагийн хичээлийн үргэлжлэх хугацаа 45 минут байна.

3.4.6. Багц цагийг энэхүү журмын зургадугаар хавсралтад заасны дагуу бүрдүүлнэ. Мэргэжилтний тухайн жилд бүрдүүлсэн багц цаг нь тогтоосон багц цагаас илүү гарсан тохиолдолд дараагийн жилд шилжүүлэн тооцохгүй.

3.4.7. Мэргэжилтэн гадаад улсад өөрийн мэргэжлийн чиглэлээр төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон тасралтгүй сургалтад суралцсан, магистр, докторын сургалтад хамрагдсан тохиолдолд багц цагийг дотоодын сургалттай адилтган үзэж, гэрчилгээ, үнэмлэх, түүнтэй адилтгах бичиг баримтыг үндэслэн тооцно.

3.4.8. Эрх бүхий сургалтын байгууллагуудаас зохион байгуулагдах төгсөлтийн дараах аливаа сургалтын багц цагийг хүчинтэйд тооцно.

3.4.9. Бүрдүүлсэн багц цаг нь зөвхөн гэрчилгээнд заасан хугацаанд хүчинтэй байна.

3.4.10. Мэргэжилтэн дор дурдсан үндэслэлийг албан ёсны бичиг баримтаар нотолсон тохиолдолд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлсэн хугацаанд оруулан тооцож, тухайн хугацаанд багц цаг бүрдүүлэхээс чөлөөлнө:

3.4.10.1. жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй;

3.4.10.2. цэргийн жинхэнэ алба хаасан, энхийг сахиулах ажиллагаанд оролцсон;

3.4.10.3. өөрийн болон гэр бүлийн гишүүний биеийн эрүүл мэндийн байдлын улмаас мэргэжлээрээ ажиллахгүйгээр эмчлүүлж, сувицуулсан.

3.4.11. Мэргэжлийн зэрэг горилогч болон мэргэжлийн зэргийг сунгах хүсэлт гаргагч нь мэргэжил дээшлүүлсэн тайлангаа бодит цагийн хэмжээ болон багц цагаар тооцож, энэ журмын гуравдугаар хавсралтад заасан загварын дагуу гаргаж, сургалтын болон холбогдох байгууллагаар баталгаажуулан, шаардсан материалын хамт ирүүлнэ.

Дөрөв.Мэргэжлийн зэрэг олгох, сунгах, цуцлах үйл ажиллагаа

4.1. Мэргэжлийн зэрэг олгох, сунгах үйл ажиллагаанд энэхүү журмын дөрөвдүгээр болон нэгдүгээр хавсралтад заасан мэргэжлийн зэрэг олгох хүрээ ба мэргэжилтэнд тавигдах шаардлагыг мөрдлөг болгон ажиллана.

4.2. Мэргэжлийн чиглэлээр доктор (academic)-ын зэрэг хамгаалсан тохиолдолд Зөвлөх зэрэг горилогчийн бичгээр уламжилсан хүсэлтийг үндэслэн зөвхөн мэргэжлийн шалгалтаас чөлөөлж, реферат хамгаалсаны дараа олгох ба 2 удаа сунгасны дараа зэргийг хугацаагүйгээр олгоно.

4.3. Зэрэг горилох, сунгах, зэрэг ахиулах мэргэжилтэн нь энэ журмын нэгдүгээр хавсралтад дурдсан шаардлагыг тус тус хангасан байна.

4.4. Зэрэг горилогч нь сургалт эхлэхээс 30 хоногийн өмнө дараах баримт, бичгийг бүрдүүлж, сургалт зохион байгуулах байгууллагад ирүүлнэ. Үүнд:

4.4.1. нэгдсэн системд бүртгүүлж, ажилтны кодоо авсан байх;

4.4.2. мэргэжлийн зэрэг олгох, сунгах шалгалтад орохыг хүссэн өргөдөл, анкет /батлагдсан маягтын дагуу/;

4.4.3. иргэний үнэмлэх, нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим лавлагаа /emongolia.mn/;

4.4.4. 3x4 хэмжээтэй 2 хувь зураг;

4.4.5. мэргэжлийн дипломын баталгаажсан хуулбар (гадаадад боловсрол эзэмшсэн бол баталгаат орчуулгыг хавсаргах);

4.4.6. мэргэжил дээшлүүлсэн сургалтын гэрчилгээний хуулбар (багц цаг тооцсон сургалтын гэрчилгээ, нэгдсэн системээс авсан гэрчилгээний QR код);

4.4.7. энэхүү журмын нэгдүгээр хавсралтад заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаарх холбогдох материал;

4.4.8. энэхүү журмын хоёрдугаар хавсралтад заасан баталгаажсан бүтээлийн тайлан ба боловсруулсан норм, дүрэм, стандарт, бичсэн ном, гарын авлага, нийтлэл, бүтээлийн фото хэлбэр, нүүр хуудас, гэрчилгээний хуулбар, гүйцэтгэсэн, боловсруулахад оролцсон зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэл, судалгааны материалуудыг хавсаргах;

4.4.9. энэхүү журмын гуравдугаар хавсралтад дурдсан сургалтын багц цаг хангасан тухай мэдэгдэл;

4.5. Мэргэжлийн зэрэг сунгуулахаар хүсэлт гаргагч нь өмнөх гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусгавар болохоос 30 хоногийн өмнө эрх бүхий сургалтын байгууллагад мэдэгдэж, бүртгүүлнэ.

4.6. Мэргэжлийн зэрэг нь мэргэшсэн ба зөвлөх гэсэн шатлалтай байна.

4.7. Зөвлөх инженер, зөвлөх менежерийн зэргийг эхний удаа 5 жилээр олгож, шаардлага хангасан тохиолдолд 5 жилээр сунгах ба зохих шалгуурыг хангасан бол 3 дахь сунгалтаас хугацаагүй олгоно.

4.8. Мэргэшсэн инженер, мэргэшсэн менежерийн зэргийг эхний удаа 3 жилээр олгож, шаардлага хангасан тохиолдолд 3 жилээр сунгах ба зохих шалгуурыг хангасан бол 3 дахь сунгалтаас хугацаагүй олгоно.

4.9. Мэргэшсэн инженер, мэргэшсэн менежер нь 5 жилийн дараа зөвлөх инженерийн зэрэг горилох сургалтад хамрагдаж болно.

4.10. Хөдөлмөрийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1 дэх хэсэгт заасны дагуу хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн ажил олгогч мэргэжлийн зэрэгтэй ажилтанд зэргийн нэмэгдлийг олгох ба зөвлөх зэрэгтэй ажилтан 20 хувь, мэргэшсэн зэрэгтэй ажилтан 15 хувийн зэргийн нэмэгдэлтэй байна.

4.11. Дараах тохиолдолд эрх бүхий сургалтын байгууллагын саналыг үндэслэн Зөвлөлөөс мэргэжлийн зэргийг цуцлах буюу гэрчилгээ (цаасан, цахим), баталгааны тэмдгийг хүчингүйд тооцон, хураана. Үүнд:

4.11.1. зэрэг цуцлуулах хүсэлтийг мэргэжилтэн өөрөө гаргасан;

4.11.2. зэргийн хугацаа хэтэрсэн;

4.11.3. 2 жил дараалан сургалтын багц цагаа хангаагүй;

4.11.4. хугацаандаа шалгалтад ороогүй, тэнцээгүй;

4.11.5. бүтээлийн тайланг худал мэдүүлсэн, эсхүл бусдын бүтээлийг ашигласан нь тогтоогдсон бол.

4.12. Зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу зөвлөх инженер, зөвлөх менежер, мэргэшсэн инженер, мэргэшсэн менежерийн зэргийг 1-2 жил хүртэл хугацаагаар цуцалж болно. Хэрэв мэргэжлийн зэргийг цуцалсан хугацаа дуусгавар болсон бол Зөвлөлд зэрэг сунгах хүсэлтээ гаргана.

4.13. Мэргэжлийн зэргээ цуцлуулсан мэргэжилтэн Зөвлөлд гэрчилгээ, баталгааны тэмдгийг хураалгана.

4.14. Мэргэжлийн зэргийн гэрчилгээ, баталгааны тэмдгийг үрэгдүүлсэн нөхцөлд холбогдох нотлох баримт, мэргэжлийн зэрэг олгосон шийдвэрийг тус тус үндэслэн сургалтын байгууллагаас нөхөн олгоно.

Тав. Мэргэжлийн зэрэгтэй мэргэжилтний эрх, үүрэг

5.1. Мэргэжлийн зэрэгтэй мэргэжилтэн нь ажил, үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, норм стандарт, дүрэм, журам, зааврын дагуу мэргэжлийн түвшинд чанартай гүйцэтгэж, инженерийн болон менежерийн ёс зүйг чанд баримтлан, мэдлэг, ур чадвараа тасралтгүй дээшлүүлж ажиллана.

5.2. Мэргэшсэн зэрэгтэй мэргэжилтэн нь гэрчилгээнд заасан эрхлэх ажил үйлчилгээний хүрээнд зураг төсөл, инженерийн тооцоолол боловсруулах, судалгаа, шинжилгээ хийх, салбарын үйлдвэрлэл, үйлчилгээний төлөвлөлт, тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг зохион байгуулах, тээврийн хэрэгслийн техник ашиглалтын тооцоо, судалгааг хийх, тоног төхөөрөмж угсрах, туршилт, тохируулга, зүгшрүүлэлт, засвар үйлчилгээ, тээвэр логистик, нийлүүлтийн сүлжээний төлөвлөлт зэрэг ажил гүйцэтгэх, хяналт тавих эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

5.3. Зөвлөх зэрэгтэй мэргэжилтэн нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

5.3.1. зөвхөн өөрөө гүйцэтгэсэн, оролцсон эсхүл удирдсан, хянаж зөвлөсөн ажлын гүйцэтгэлийн тайлан, дүгнэлт, техникийн акт, баримт бичиг, зураг төсөлд гарын үсэг зурж, хувийн тэмдгээ дарж баталгаажуулах;

5.3.2. автотээврийн салбарын судалгаа шинжилгээний ажил удирдах, зөвлөх ажил үйлчилгээ үзүүлэх, зураг, төсөл, хөтөлбөр удирдан гүйцэтгэх, бусдын хийсэн ажил, үйлчилгээнд хяналт тавих, шалгах, дүгнэлт гаргах, зөвлөх, мэргэшсэн зэрэг гориллогчийн бүтээлийн тайлан, илтгэлийн хураангуй /реферат/ хамгаалахад шүүмж хийх;

5.3.3. Салбарын чиглэлээр боловсруулж буй хууль эрх зүйн акт, норм, дүрэм, стандарт, техникийн баримт бичиг боловсруулах, санал дүгнэлт өгөх болон мөн өөрийн мэргэжлийн зэргийн хүрээнд мэргэжлийн зэрэг гориллогчдод зориулсан сургалтад мэдээлэл хийх;

5.4. Мэргэжлийн зэрэгтэй мэргэжилтэн нь жил бүр тухайн жилд хийж гүйцэтгэсэн ажлын баталгаажуулсан тайлангаа сургалтын эрх бүхий байгууллагад ирүүлж, сургалтын нэгдсэн систем дэх хувийн хэргээ баяжуулна.

5.5. Зөвлөх ба мэргэшсэн зэрэгтэй инженер, менежер нь тавдугаар хавсралтад тусгагдсан баталсан загвар бүхий гэрчилгээ, баталгааны тэмдэгтэй байна.

Зургаа. Хариуцлага

6.1. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд байгууллага, иргэн холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

6.2. Мэргэжлийн зэрэгтэй мэргэжилтэн нь өөрийн бие дааж гүйцэтгэсэн болон удирдсан ажлын чанарыг хянаж, баталгаажуулсан үр дүн болон өөрийн буруугаас учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрэн хариуцна.

---o0o---

*Автотээврийн салбарын мэргэжилтэй
ажилтан бэлтгэх, давтан сургах,
мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг
олгох журмын нэгдүгээр хавсралт*

Автотээврийн салбарын мэргэжилтэнд мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох/сунгахад тавигдах шаардлага

Мэргэжил	Горилж буй мэргэжлийн н зэрэг	Тавигдах шаардлага		Мэргэжлийн зэрэг олгох шалгаруулалтын үйл ажиллагааны үе шат	Мэргэжилтний мэргэжлийн зэргийг горилох, сунгах, цуцлах үе шат
Авто инженер, авто хөдөлгүүрт механик инженер, машин механизмын ашиглалтын инженер, мехатроникийн инженер, машин үйлдвэрлэлийн инженер, үйлдвэрийн механикжуулалтын инженер, барилга замын машин механизмын инженер, машин үйлдвэрийн инженер, машины электрон системийн инженер,	Мэргэшсэн инженер	Боловсрол	Боловсролын стандартыг хангасан автотээврийн салбарын чиглэлээр их, дээд сургууль төгсөж, дээд (дипломын, бакалаврын, магистрын, доктор) боловсрол эзэмшсэн байх	- Багц цагаа тооцуулж баталгаажуулна. - Дадлагын цагийг тооцуулж баталгаажуулна. - Мэргэжлийн болон ур чадварын шалгалт нь (салбарын хууль, эрх зүйн баримт бичиг, норм норматив, стандарт, дүрэм, журам, заавар) мэдлэг, ур чадварыг шалгах тест байх ба авбал зохих нийт онооны 80 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд тэнцсэнд тооцно. - Мэргэжилтний бүтээл, туршлагыг магадлан, үнэлэх (батлагдсан загварын дагуу гаргасан бүтээлийн тайланг хянан магадлана.)	- Мэргэшсэн инженерийн зэрэг горилох/сунгуулах хүсэлтийг гаргахдаа хийсэн ажил болон мэргэжил дээшлүүлсэн талаарх тайлан, тодорхойлолтын хамт зөвлөлд ирүүлнэ. - Сургалтад хамрагдана. - Мэргэшсэн инженерийн зэргийн шалгалтад 80 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд бүтээлийн тайлан хамгаалалтад орно. - Өөрийн биеэр хийсэн ажил/бүтээлийн тайлангаа шалгалтын комисст тайлагнана. - Мэргэшсэн зэрэгтэй инженер нь 3 жил тутамд зэргээ сунгуулах ба 3 дахь сунгалтаас хугацаагүйгээр олгоно.
		Ажилласан жил	Дипломын дээд боловсрол эзэмшсэнээс хойш мэргэжлээрээ 6-аас дээш жил тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх		
			Бакалаврын зэрэгтэй бол 5-аас дээш жил мэргэжлээрээ тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх		
			Магистрын зэрэгтэй бол 4-өөс дээш жил мэргэжлээрээ тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх		

Тээврийн менежмент, нийлүүлэлтийн сүлжээ, логикийн мэргэжилтнүүд	Мэргэшсэн менежер	Боловсрол	Боловсролын стандартыг хангасан автотээврийн салбарын чиглэлээр их, дээд сургууль төгсөж, дээд (дипломын, бакалаврын, магистрын, доктор) боловсрол эзэмшсэн байх	1. Багц цагаа тооцуулж баталгаажуулна. 2. Дадлагын цагийг тооцуулж баталгаажуулна. 3. Мэргэжлийн болон ур чадварын шалгалт нь (салбарын хууль, эрх зүйн баримт бичиг, норм норматив, стандарт, дүрэм, журам, заавар) мэдлэг, ур чадварыг шалгах тест байх ба авбал зохих нийт онооны 80 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд тэнцсэнд тооцно. 4. Мэргэжилтний бүтээл, туршлагыг магадлан, үнэлэх (батлагдсан загварын дагуу гаргасан бүтээлийн тайланг хянан магадлана.)	■ Мэргэшсэн менежерийн зэрэг горилох/сунгуулах хүсэлтийг гаргахдаа хийсэн ажил болон мэргэжил дээшлүүлсэн талаарх тайлан, тодорхойлолтын хамт зөвлөлд ирүүлнэ. ■ Сургалтад хамрагдана. ■ Мэргэшсэн менежерийн зэргийн шалгалтад 80 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд бүтээлийн тайлан хамгаалалтад орно. ■ Өөрийн биеэр хийсэн ажил/бүтээлийн тайлангаа шалгалтын комисст тайлагнана. ■ Мэргэшсэн зэрэгтэй менежер нь 3 жил тутамд зэргээ сунгуулах ба 3 дахь сунгалтаас хугацаагүйгээр олгоно.
		Ажилласан жил	Дипломын дээд боловсрол эзэмшсэнээс хойш мэргэжлээрээ 6-аас дээш жил тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх		
			Бакалаврын зэрэгтэй бол 5-аас дээш жил мэргэжлээрээ тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх		
			Магистрын зэрэгтэй бол 4-өөс дээш жил мэргэжлээрээ тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх		
Авто инженер, авто хөдөлгүүрт механик инженер, машин механизмын ашиглалтын инженер, мехатроникийн инженер, машин үйлдвэрлэлийн инженер, үйлдвэрийн механикжуулалтын инженер, барилга замын машин механизмын инженер, машин үйлдвэрийн инженер, машины	Зөвлөх инженер	Боловсрол	Боловсролын стандартыг хангасан автотээврийн салбарын чиглэлээр их, дээд сургууль төгсөж, дээд (дипломын, бакалаврын, магистрын, доктор) боловсрол эзэмшсэн байх, магистрын зэрэгтэй байх	1. Багц цагаа тооцуулж баталгаажуулна. 2. Дадлагын цагийг тооцуулж баталгаажуулна. 3. Мэргэжилтний бүтээл, туршлагыг батлагдсан загварын дагуу гаргасан бүтээлийн тайланг хянан магадлаж, үнэлэх; 4. Мэргэжлийн болон ур чадварын шалгалт нь (салбарын хууль, эрх зүйн баримт бичиг, норм норматив, стандарт, дүрэм, журам, заавар) мэдлэг, ур чадварыг шалгах тест байх ба авбал зохих нийт онооны 90 ба түүнээс дээш хувийн амжилт	1. Зөвлөх инженерийн зэрэг горилох/сунгуулах хүсэлтийг гаргахдаа хийсэн ажил болон мэргэжил дээшлүүлсэн талаарх тайлан, тодорхойлолтын хамт зөвлөлд ирүүлнэ. 2. Сургалтад хамрагдана. 3. Өөрийн биеэр хийсэн ажил/бүтээлийн тайлангаа Зөвлөлд тайлагнана. 4. Зөвлөх инженерийн зэргийн шалгалтад 90 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд сэдвийн хамгаалалтад орно. 5. Сонгосон буюу оноож өгсөн сэдвээр реферат бичиж, хамгаалан, Зөвлөлийн
		Ажилласан жил	Мэргэжлээрээ 10 ба түүнээс дээш жил, мэргэшсэн зэрэг авснаас хойш мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш жил тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх, автотээврийн ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавих дадлага, туршлагатай байх		

электрон системийн инженер,			Мэргэжлийн хүрээний чиглэлээр доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан тохиолдолд Зөвлөх зэрэг горилогчийн бичгээр уламжилсан хүсэлтийг үндэслэн зөвхөн мэргэжлийн шалгалтаас чөлөөлөх	үзүүлсэн тохиолдолд тэнцсэнд тооцно. 5. Сонгосон буюу оноож өгсөн сэдвээр реферат бичиж, хамгаалан, Зөвлөлийн гишүүдийн 80 ба түүнээс дээш хувийн санал авсан тохиолдолд тэнцсэнд тооцно.	гишүүдийн 80 ба түүнээс дээш хувийн санал авсан тохиолдолд тэнцсэнд тооцно. 6. Зөвлөх зэргийг 5 жилийн хугацаагаар олгож, 2 удаа сунгаж баталгаажуулах ба 3 дахь сунгалтаас хугацаагүйгээр олгоно.
Тээврийн менежмент, нийлүүлэлтийн сүлжээ, логикийн мэргэжилтнүүд	Зөвлөх менежер	Боловсрол	Боловсролын стандартыг хангасан автотээврийн салбарын чиглэлээр их, дээд сургууль төгсөж, дээд (дипломын, бакалаврын, магистрын, доктор) боловсрол эзэмшсэн байх	1. Багц цагаа тооцуулж баталгаажуулна. 2. Дадлагын цагийг тооцуулж баталгаажуулна. 3. Мэргэжилтний бүтээл, туршлагыг батлагдсан загварын дагуу гаргасан бүтээлийн тайланг хянан магадлаж, үнэлэх; 4. Мэргэжлийн болон ур чадварын шалгалт нь (салбарын хууль, эрх зүйн баримт бичиг, норм норматив, стандарт, дүрэм, журам, заавар) мэдлэг, ур чадварыг шалгах тест байх ба авбал зохих нийт онооны 90 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд тэнцсэнд тооцно. 5. Сонгосон буюу оноож өгсөн сэдвээр реферат бичиж, хамгаалан, Зөвлөлийн гишүүдийн 80 ба түүнээс дээш хувийн санал авсан тохиолдолд тэнцсэнд тооцно.	1. Зөвлөх менежерийн зэрэг горилох/сунгуулах хүсэлтийг гаргахдаа хийсэн ажил болон мэргэжил дээшлүүлсэн талаарх тайлан, тодорхойлолтын хамт зөвлөлд ирүүлнэ. 2. Сургалтад хамрагдана. 3. Өөрийн биеэр хийсэн ажил/бүтээлийн тайлангаа Зөвлөлд тайлагнана. 4. Зөвлөх менежерийн зэргийн шалгалтад 90 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд сэдвийн хамгаалалтад орно. 5. Сонгосон буюу оноож өгсөн сэдвээр реферат бичиж, хамгаалан, Зөвлөлийн гишүүдийн 80 ба түүнээс дээш хувийн санал авсан тохиолдолд тэнцсэнд тооцно. 6. Зөвлөх зэргийг 5 жилийн хугацаагаар олгож, 2 удаа сунгаж баталгаажуулах ба 3 дахь сунгалтаас хугацаагүйгээр олгоно.
		Ажилласан жил	Мэргэжлээрээ 10 ба түүнээс дээш жил, мэргэшсэн зэрэг авснаас хойш мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш жил тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх, автотээврийн ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавих дадлага, туршлагатай байх		

Автомээврийн салбарын мэргэжилтэй
ажилтан бэлтгэх, давтан сургах,
мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг
олгох журмын хоёрдугаар хавсралт

БҮТЭЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ЗАГВАР

.....-ийн бүтээлийн тайлан
/эцэг, эхийн нэр/ /нэр/

№	Бүтээлийн Нэр	Гүйцэтгэсэн хугацаа, он, сар	Өөрөө гүйцэтгэсэн, оролцсон, хэрэгжүүлсэн аль нь болох	Шийдвэр гаргасан, баталгаажуулсан байгууллага, албан тушаалтан
1				
2				
...				

Тайлан бичсэн мэргэжилтэн : / /
/гарын үсэг/ /нэр/

Хянаж баталгаажуулсан: / /
/гарын үсэг/ /нэр/
/тэмдэг/

..... / /
/гарын үсэг/ /нэр/
/тэмдэг/

Автоматээрйин салбарын мэргэжилтэй
ажилтан бэлтгэх, давтан сургах,
мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг
олгох журмын гуравдугаар хавсралт

БАГЦ ЦАГ ХАНГАСАН ТУХАЙ МЭДЭГДЭЛ

.....-ийн бүтээлийн тайлан
/эцэг, эхийн нэр/ /нэр/

Танхимын хэлбэрээр багц цаг хангасан байдал						
№	Сургалтын нэр, ерөнхий агуулга, сэдэв	Хугацаа он, сар, өдөр	Хамтарч оролцсон байдал	Бодит цагийн хэмжээ	Багц цаг болон багц цагт шилжүүлсэн байдал	Сургалт зохион байгуулсан байгууллагын нэр
1						
2						
...						
Танхимын бус хэлбэрээр багц цаг хангасан байдал						
№	Оролцож хэрэгжүүлсэн арга хэмжээний хэлбэр	Хугацаа	Оролцсон үүрэг	Бодит ажилласан цаг	Багц цаг	Холбогдох байгууллага, аж ахуй нэгж
1						
2						
...						

Тайлан бичсэн мэргэжилтэн : / /
/гарын үсэг/ /нэр/

Хянаж баталгаажуулсан: / /
/гарын үсэг/ /нэр/
/тэмдэг/

*Автотээврийн салбарын мэргэжилтэй
ажилтан бэлтгэх, давтан сургах,
мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг
олгох журмын дөрөвдүгээр хавсралт*

АВТОТЭЭВРИЙН САЛБАРЫН МЭРГЭЖИЛТНИЙ МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ХҮРЭЭ

Салбарын мэргэжилтний суурь мэргэжил, мэргэжлийн мэдлэг ур чадвар, туршлагын үнэлгээнээс хамааруулан дараах хүрээнд мэргэшсэн ба зөвлөх гэсэн шатлал бүхий мэргэжлийн зэрэг олгоно.

Мэргэжлийн зэргийн шатлал	Мэргэжил	Мэргэжлийн зэргийн хамрах хүрээ
Мэргэшсэн	Инженер	1. Авто инженерчлэл /071601/ - /тээврийн хэрэгслийн техникийн байдлын хяналтын үзлэг, засвар үйлчилгээ, зохион бүтээлт, хийц/; 2. Машины электрон систем /071602/; 3. Авто хөдөлгүүрийн механик инженерчлэл /071603/; 4. Механик инженерчлэл /071501/*; 5. Металлурги, металлын технологи /071502/; 6. Үйлдвэрлэлийн механикжуулалт /071503/; 7. Машин механизмын ашиглалт /071504/; 8. Мехатроник /071505/; 9. Машин үйлдвэрлэлийн технологи /071507/; 10. Тээврийн үйлчилгээ /104101/ - /удирдлага, зохион байгуулалт/; 11. Нийлүүлэлтийн сүлжээ, логистик /041308/;
	Менежер	
Зөвлөх	Инженер	
	Менежер	

* Тайлбар: Зөвхөн автотээврийн салбарт хамаарах механик инженерүүд хамрагдана.

---o0o---

*Автомээврийн салбарын мэргэжилтэй
ажилтан бэлтгэх, давтан сургах,
мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг
олгох журмын тавдугаар хавсралт*

Гэрчилгээний загвар /Монгол ба англи хэлээр/


Гэрчилгээний цаасны хэмжээ:

Өргөн – 210 мм
Өндөр – 297 мм

Гэрчилгээнд тусгах бичиглэл:

1. Гэрчилгээ олгосон байгууллагын нэр;
2. Сургалтын байгууллагын нэр;
3. Гэрчилгээ авч буй мэргэжилтний цээж зураг;
4. Гэрчилгээ олгосон шийдвэр;
5. Гэрчилгээ олгосон огноо;
6. Гэрчилгээний хүчинтэй хугацаа;
7. Гарын үсэг, тамга тэмдэг.

Баталгааны тэмдгийн загвар:



---o0o---

Автотээврийн салбарын мэргэжилтэй
ажилтан бэлтгэх, давтан сургах,
мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг
олгох журмын зургаадугаар хавсралт

БАГЦ ЦАГИЙН БҮРДЭЛ

№	Багц цагийг бүрдүүлэх хэлбэр	Тооцох багц цаг		Автотээврийн салбарын мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд бүрдүүлэх, баталгаажуулах баримт
1	А. Сургалтын хэлбэр			
1.1.	А-1. Багц цагийн богино хугацааны сургалт			
1.1.1.	Тухайн жилд автотээврийн салбарын сургагч багшаар ажиллаж, сургалт эрхлэх байгууллагад зохион байгуулагдах мэргэшүүлэх сургалт удирдах	3		сургагч багшийн гэрчилгээ, мэргэшүүлэх сургалт удирдах тухай сургалт эрхлэх байгууллагын даргын тушаал, тайлан
1.1.2.	Тухайн жилд үндэсний чиглүүлэгч багшаар ажиллаж, сургагч багш бэлтгэх сургалтад 2-оос доошгүй удаа оролцох	зөвлөх	6	чиглүүлэгч багшийн гэрчилгээ, сургагч багш бэлтгэх сургалтын чиглүүлэгч багшаар ажиллуулах тухай шийдвэр, тайлан
		мэргэшсэн	3	
1.1.3.	Багц цагийн богино хугацааны сургалт удирдах	2 цаг тутамд 0.5		ЗТХЯ-наас баталсан сургалтын хөтөлбөр, сургалт удирдах тухай сургалт эрхлэх байгууллагын даргын тушаал, тайлан
1.1.4.	Багц цагийн богино хугацааны сургалтад суралцах	4 цаг тутамд 0,5		сургалтын хөтөлбөр, бүртгэл, гэрчилгээ
1.2.	А-2. Мэргэжил дээшлүүлэх сургалт			
1.2.1.	Мэргэжил дээшлүүлэх сургалтад суралцах	зөвлөх	6	зөвшөөрч баталсан сургалтын хөтөлбөр, бүртгэл, гэрчилгээ
		мэргэшсэн	3	
1.3.	А-3. Мэргэшүүлэх сургалт			
1.3.1.	Үндсэн мэргэшлийн сургалтад суралцах	зөвлөх, мэргэшсэн	Төгссөн байх, жилд-6	бүртгэл, тушаалаар олгосон мэргэшлийн үнэмлэх
1.3.2.	Төрөлжсөн мэргэшлийн сургалтад суралцах	зөвлөх	Төгссөн байх, жилд-6	
		мэргэшсэн	Төгссөн байх, жилд-3	
2.	Б. Сургалтын бус хэлбэр			
2.1.	Тухайн жилд мэргэшлийн зэрэг хамгаалсан бол	зөвлөх	6	бүртгэл, тушаалаар олгосон мэргэшлийн зэргийн гэрчилгээ
		мэргэшсэн	3	

2.2.	Тухайн жилд боловсролын, эрдмийн зэрэг хамгаалсан бол	автотээврийн салбарын магистрын зэрэг	3	бүртгэл, Шинжлэх ухааны доктор, доктор, магистрын зэргийн диплом
		автотээврийн салбарын докторын зэрэг	6	
		автотээврийн салбарын шинжлэх ухааны докторын зэрэг	6	
		бусад чиглэлийн магистрын зэрэг	1.5	
		бусад чиглэлийн докторын зэрэг	3	
2.3.	Тухайн жилд боловсролын зэргийн ажил удирдаж хамгаалуулсан бол	Автотээврийн салбарын магистрын ажил	1	бүртгэл, удирдаж хамгаалуулсаныг нотлох баримт
		Автотээврийн салбарын докторын ажил	2	
2.1.	Автотээврийн салбарын чиглэлээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт эрх бүхий этгээдийн шийдвэрээр томилогдон ажилласан бол	4		Батлагдсан хууль, тушаал, шийдвэр
2.2.	Хуулийг дагалдан гарах дүрэм, журмын төслийг боловсруулж, батлуулсан, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн бол	3		Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн бүртгэлийн дугаар, тушаал
2.6.	Мэргэжлийн чиглэлээр эрдэм шинжилгээний бага хурал, семинар, мэргэжлийн зөвлөгөөнд оролцсон бол	олон улсын хэмжээнд	2	Хөтөлбөр, гэрчилгээ
		улсын хэмжээнд	1	
		орон нутгийн хэмжээнд	0.5	
2.7.	Мэргэжлийн чиглэлээр эрдэм шинжилгээний бага хурал, семинар, мэргэжлийн зөвлөгөөнд илтгэл тавьсан бол	олон улсын хэмжээнд	3	Хөтөлбөр, илтгэлийн хураангуй
		улсын хэмжээнд	2	
		орон нутгийн хэмжээнд	1	
2.8.	Мэргэжлийн ном, мэргэжлийн сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл, шүүмж бичиж хэвлүүлсэн бол	олон улсын хэмжээнд	4	Өгүүлэл, шүүмжийн холбогдох линк, хураангуй
		улсын хэмжээнд	2	
2.9.	Мэргэжлийн чиглэлээр олон улсын цахим сургалтын платформд хандаж суралцсан бол	1		Сэдэв, гэрчилгээ

2.10.	Мэргэжлийн сурах бичиг, нэг сэдэвт бүтээл, гарын авлага нийтлүүлсэн бол	Зохиож нийтлүүлсэн бол	3	Хэвлүүлсэн бүтээл
		Хамтран зохиож нийтлүүлсэн бол	1	
2.11.	Мэргэжлийн чиглэлээр олон улсын болон улсын хэмжээний уралдаан, тэмцээн, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан, удирдсан, шүүгчээр ажилласан бол	1		Тайлан
2.12.	Салбарын төсөл хөтөлбөр бичсэн, судалгаанд оролцсон бөгөөд судалгааны ажил, тайлан хэвлэгдсэн бол	1		Хэвлүүлсэн судалгаа
2.13.	Стандарт, заавар боловсруулахад оролцсон бөгөөд стандарт, заавар батлагдсан бол	1		Батлагдсан стандарт, заавар
2.14.	Шинэ арга боловсруулах, инноваци, шинэ технологи гаргаж, нэвтрүүлэх	2		Тухайн хүний нэр бүхий шинэ арга, инноваци, шинэ технологийн бүтээлийн хуулбар (мэдээний сангийн бүртгэлд давхцаагүй байх)
2.15.	Мэргэжлийн нийгэмлэг, холбооноос зохион байгуулсан сайн дурын үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон бол	1 багц цаг хүртэл		Мэргэжлийн нийгэмлэг, холбооны тодорхойлолт
2.16.	Төрөлжсөн мэргэшлийн сургалтад суралцагч инженер, техникийн ажилтны хувьд сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан сайн дурын ажилд идэвхтэй оролцсон бол	1 багц цаг хүртэл		Сургалт эрхлэх байгууллагын бүртгэл

---o0o---